

3

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ТУШААЛ**

2016 оны 10 сарын 07 өдөр

Дугаар A/02

Арвайхээр

Төрийн алба хаасан хугацааны
нэмэгдэл олгох тухай

Монгол Улсын Засгийн Газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Мэргэжилтэн Х.Мөнхцэцэгийн төрийн албанд ажилласан хугацааны нэмэгдлийг 10.0 хувиар тогтоосугай.
2. Х.Мөнхцэцэгт төрийн албанд ажилласан хугацааны нэмэгдлийг 2016 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн олгохыг ня-бо /П.Дуламсүрэн/-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



О.ТҮМЭНЖАРГАЛ

320009

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2016 оны 12 сарын 10 өдөр

Дугаар А/04

Арвайхээр

Эд хөрөнгийн тооллого хийх тухай

Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дугаар заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлүүдийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2016 оны жилийн эцсийн хөрөнгийн тооллого явуулах ажлын хэсгийг доорхи бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Х.Мөнхцэцэг. Мэргэжилтэн

Гишүүд: Д.Отгоннасан. Гэрээт ажилтан

Д.Чулуунцэцэг. Судлаач

2. Эд хөрөнгийн тооллогыг 12 сарын 25-ны дотор багтаан заавар журмын дагуу явуулж дүн мэдээг тооцож гаргахыг ажлын хэсгийн ахлагч /Х.Мөнхцэцэг/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



О.ТҮМЭНЖАРГАЛ

320015

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2016 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/05

Арвайхээр

Үр дүнгийн урамшуулал олгох тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4.2 дугаар заалт, Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2016 оны үр дүнгийн гэрээний үнэлгээгээр 97 хувь буюу "А" үнэлгээтэй дүгнэгдсэн мэргэжилтэн Х.Мөнхцэцэгийг үндсэн цалингийн 55 хувь, үр дүнгийн гэрээний үнэлгээгээр 93 хувь буюу "А" үнэлгээтэй дүгнэгдсэн мэргэжилтэн П.Дуламсүрэн, Э.Өүлэнц нарыг үндсэн цалингийн 45 хувь, үр дүнгийн гэрээний үнэлгээгээр 86 хувь буюу "В" үнэлгээтэй дүгнэгдсэн мэргэжилтэн Ц.Должинсүрэнг үндсэн цалингийн 27 хувиар тус тус тооцож үр дүнгийн урамшуулал олгосугай.

2. Үр дүнгийн урамшуулалыг 2016 оны 12 дугаар сард багтаан дээрх хувиар тооцож олгохыг нягтлан бодогч /П.Дуламсүрэн/-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



О.ТҮМЭНЖАРГАЛ

320017

7

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ТУШААЛ**

2016 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/06

Арвайхээр

Нэгж байгуулах тухай

Аймгийн Засаг даргын 2012 оны “Журам батлах тухай” а/84 дугаар захирамжийн 3.1, 3.2 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нэгжийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Нэгжийн ахлагч: Х.Мөнхцэцэг. Мэргэжилтэн

Гишүүд: Д.Отгоннасан. Гэрээт ажилтан

Ц.Гаваа. Судлаач

2. Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах дүрэм журмыг мөрдлөг болгон ажиллаж, хийсэн ажлын тайлан мэдээг улирал тутам Хэлтсийн хамт олны хуралд тайлагнахыг нэгжийн ахлагч /Х.Мөнхцэцэг/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



О.ТҮМЭНЖАРГАЛ

320019

8

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ТУШААЛ**

2016 оны 12 сарын 16 өдөр

Дугаар A/07

Арвайхээр

Дотоод журам батлах тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1, 130.2 дугаар заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Статистикийн хэлтсийн ажилчдын дотоод журмыг хавсралтаар баталсугай.
2. Дотоод журмыг аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд хянуулж ажиллах, бусад ажилтан албан хаагчдад танилцуулж, дотоод журамд заагдсан заалтуудыг хэрэгжүүлэхэд хяналт тавьж ажиллахыг мэргэжилтэн /Э.Өүлэн/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



О.ТҮМЭНЖАРГАЛ

320021

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2016 оны 09 сарын 23 өдөр

Дугаар 8/03

Арвайхээр

Ажил хавсран гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 26.1 дэх заалтыг үндэслэн
ТУШААХ нь:

1. Мэргэжилтэн Пүрэвдорж овогтой Дуламсүрэнд хэлтсийн нягтлан бодогчийн ажлыг, мэргэжилтэн Эрхэмбаяр овогтой Өүлэнд няравын ажлыг 2016 оны 09 дүгээр сарын 23-ний өдрөөс эхлэн тус тус хавсран гүйцэтгүүлсүгэй.
2. Хэлтсийн нягтлан бодох бүртгэл, няравын тайлан тооцоог холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэн, тайлагнахыг мэргэжилтэн /П.Дуламсүрэн/, /Э.Өүлэн/ нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



О.ТҮМЭНЖАРГАЛ

320007

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2016 оны 11 сарын 02 өдөр

Дугаар 8/04

Арвайхээр

Гэрээт ажилтан томилж, чөлөөлөх тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалт, 43 дугаар зүйл, Үндэсний статистикийн хорооны дотоод журмын 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хэлтсийн гэрээт ажилтан жолооч Батаа овогтой Лувсандагва нь өөр ажилд шилжсэнтэй холбогдуулан 2016 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөр дуусгавар болгон ажлаас чөлөөлж, Даваацэрэн овогтой Отгоннасанг гэрээт ажилтнаар, Найсүрэн овогтой Ганбаатарыг гэрээт ажилтан жолоочоор 2016 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Б.Лувсандагватай 2016 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөр тасалбар болгон эд хөрөнгө, санхүүгийн тооцоо хийж дуусган, Д.Отгоннасан, Н.Ганбаатар нарыг сард 414000 /Дөрвөн зуун арван дөрвөн мянган/ төгрөгөөр цалинжуулахыг нягтлан бодогч /П.Дуламсүрэн/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



О.ТҮМЭНЖАРГАЛ

320011

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/02

Арвайхээр

Статистикийн 2017 оны мэдээ, тайлангийн
график батлах тухай

Үндэсний статистикийн хорооны даргын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/79 тоот тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Статистикийн хэлтэст сумаас 2017 онд ирүүлэх албан ёсны мэдээ, тайлангийн графикийг нэгдүгээр хавсралтаар баталж мөрдүүлсүгэй.
2. Мэдээ, тайланг графикт хугацаанд нь батлагдсан маягт, аргачлалын дагуу үнэн зөв, бүрэн хамралттайгаар гарган ирүүлж байхыг сумын статистикийн ажил хариуцсан ажилтанд үүрэг болгосугай.
3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг мэргэжилтэн /Х.Мөнхцэцэг/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



О.ТҮМЭНЖАРГАЛ

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 8/101

Арвайхээр

Ажил хавсран гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 26.1 дэх заалт, Үндэсний Статистикийн Хорооны тамгын газрын даргын 2016 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/12 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хэлтсийн гэрээт ажилтан Д.Отгоннасанд архив, бичиг хэрэг, няравын ажлыг 2017 оны 05 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хавсран гүйцэтгүүлсүгэй.
2. Архив, бичиг хэрэг, няравын ажлыг хавсран гүйцэтгэж байгаа Д.Отгоннасанд үндсэн цалингийн 15 хувиар тооцон 2017 оны 05 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн цалингийн нэмэгдэл олгохыг нягтлан бодогч /П.Дуламсүрэн/-д үүрэг болгосугай.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан 2016 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн Б/03 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



О.ТҮМЭНЖАРГАЛ